





ГАМШГИЙН
ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛАХ

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

2025 оны I улирал

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүн дарга, орлогч дарга, нарийн бичиг, 21 гишүүнтэйгээр шинэчлэгдэн батлагдсан.

Үндэсний зөвлөлийн 2024 оны хуралдааныг 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуралдааны шийдвэр болгон нийт 10 бүлэг 32 арга хэмжээ бүхий зөвлөмжийг батлан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд болон орон нутгийн зөвлөлд хүргүүлсэн.



ГЭБҮЗ - ийн
нэмэлт мэдээллийг
энэхүү холбоосоор
авах боломжтой.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЗИ, НОМХОН ДАЛАЙН САЙД НАРЫН БАГА ХУРАЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурал Япон Улсын Сендай хотноо 2015 онд зохион байгуулагдаж “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн хүрээ” баримт бичгийг батлан гаргасан. Тус баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын сайд нарын бага хурлыг хоёр жил тутамд зохион байгуулж ирсэн.

Энэхүү хурлыг 2016 онд БНЭУ-ын нийслэл Шинэ Дели хот, 2018 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, 2022 онд Австралийн Холбооны Улсын Брисбен хотноо амжилттай зохион байгуулж байсан билээ.

Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо 2024 оны 10 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд “Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн сайд нарын бага хурал”-ыг зохион байгуулсан. Тус бага хуралд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан ОБЕГ, орон нутгийн Онцгой байдлын газар, олон улсын, үндэсний болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчид оролцсон юм.

Бага хурлын уриа: “2030 он: Ази, Номхон далайн бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг нэмэгдүүлэх нь”



Тус бага хуралд нийт 55 орны 4000 гаруй төлөөлөл хүрэлцэн ирж, 7000 орчим хүн цахим хэлбэрээр оролцсон өндөр үр дүн дагуулсан хурал болж өндөрлөсөн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн сайд нарын бага хуралд дараах асуудлыг онцлон тэмдэглэсэн. Үүнд:

- Ази, Номхон далайн бүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах сайд нарын бага хурлаас тус бүс нутагт 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, бүс нутгийн улс орнуудыг улс төрийн үүрэг амлалтаа 2030 он гэхэд хэрэгжүүлсэн байхыг улс орнуудад уриалсан.
- Гамшгаас эртнээс сэрэмжлүүлэх, эрт авах арга хэмжээг хэрэгжүүлэх Засгийн газар хоорондын холбоо байгуулах уриалга гаргасан.
- 2022-2030 онд Сургуулийн цогц аюулгүй байдал хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг амлалтыг биелүүлэхэд ахиц дэвшил гаргах, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд хэнийг үл орхигдуулах, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, алслагдсан нутгийн иргэд олон нийтийн оролцоог хангах, Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сэргээн босгох үйл ажиллагааны бэлэн байдлыг хангахад хөрөнгө оруулалт хийх нь сайжруулан барьж байгуулах үйл ажиллагааг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй онцолсон.





GLOBAL PLATFORM FOR
DISASTER RISK REDUCTION



SWITZERLAND
2-6 JUNE 2025

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМЫН VIII ХУРАЛДААН

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформын VIII хуралдааныг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар (UN-DRR), Швейцарын Засгийн газар хамтран 2025 оны 06 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулна.



Хуралдааны нэгдсэн уриа:

“ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ
ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХИЙН
ЧУХЛЫГ ӨДӨР БҮР САНАЖ,
ӨНӨӨДРӨӨС ТОДОРХОЙ
ҮЙЛДЭЛ ХИЙ”

Одоогийн болон ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг хурдацтай өөрчлөгдөж буй уур амьсгалд тохируулан удирдах нь

Нэг ч хүнийг орхигдуулахгүй байхад жендерийн тэгш байдал, хүртээмж, оролцоог эрхэмлэх

Хамтын тогтвортой ирээдүйн төлөө шаардлагатай арга хэмжээг эрчимжүүлэх


Зорилго:

- “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх
- Сурагчдын гамшиг, гамшгийн эрсдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг ойлголтыг олгох зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар хамтран зохион байгууллаа.

Хугацаа:

- Ерөнхий боловсролын сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн II улирлын бие даалтын 7 хоног
- Нийслэл: 2025.03.31-2025.04.04
- Орон нутаг: 2025.03.24-28

Бие
даалтын **7**
ХОНОГ



“МОНГОЛ ХҮН БА ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ”



Монгол Улсын
хэмжээнд тохиолдсон
гамшиг, аюулт
үзэгдэл, ослын
статистик мэдээ



Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмжийн 4.2-т “Монгол хүн ба эрсдэлийн боловсрол” аяныг улсын хэмжээнд зохион байгуулахаар тусгасан.

ЭНЭ ХҮРЭЭНД 2025
ОНД “МОНГОЛ ХҮН
БА ЭРСДЭЛИЙН
БОЛОВСРОЛ” АЯНЫГ
УЛСЫН ХЭМЖЭЭНД
ӨРНҮҮЛНЭ.

Аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнээс:

- Гамшгийн эрсдэлийн асуудлаар 2025 оны 10 дугаар сарын дөрөвдүгээр долоо хоногт улсын хэмжээнд телевизийн шууд нэвтрүүлэг зохион байгуулж, холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулах
- Бүх шатны боловсрол, эрүүл мэндийн байгууллагад гамшгийн үед ашиглагдах зам гарцыг чөлөөлөх хөдөлгөөн өрнүүлэх
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах уламжлалт арга, ухааныг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр богино хэмжээний судалгааны ажил хийж, үр дүнг иргэд олон нийтэд хүргэх
- Аймаг, нийслэлийн хэмжээнд удирдамж боловсруулж сургуулийн насны хүүхдүүдэд “Гамшгийн эрсдэл” сэдвээр гар зургийн уралдаан зохион байгуулах
- Аймаг, орон нутгийн хэмжээнд “Эрсдэлгүй гудамж”-ийг бий болгох зорилгоор нэгээс доошгүй гудамж, талбайг сонгож тохижуулах

МОНГОЛ ХҮН
БА ЭРСДЭЛИЙН
БОЛОВСРОЛ

“КАДРИ” ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ



НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн бүсийн газар, НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагчийн газрын удирдлага дор КАДРИ түншлэлийн багаас НҮБ-ын Монгол Улс дахь төрөлжсөн байгууллагууд, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Монгол Улсын гамшиг, уур амьсгалын эрсдэлийг удирдах чадавхын үнэлгээг тус түншлэлийн багийн үнэлгээний аргачлалын дагуу 2023-2024 онд хийж гүйцэтгэсэн.

Энэхүү чадавхын үнэлгээг хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, салбар хоорондын зохицуулалт гэсэн үндсэн 6 салбарын хүрээнд хийж үнэлгээний үр дүнд салбар тус бүрээр нийт 157 зөвлөмж, үүнээс зайлшгүй хэрэгжүүлэхийг тусгайлан зөвлөсөн 45 зөвлөмжийг гаргасан.


Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор салбар, яам, агентлагийн төлөөлөлтэй санал солилцохуулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

Зөвлөмж /Бүлэг, агуулга/	Засаглал		Хэрэгжилт		Санхүүжилт		Мэдлэг мэдээлэл, техник технологи		Нийт	
	*	**	*	**	*	**	*	**	*	**
Салбар хооронд (ОБЕГ)	7	3	14	3	7	3	16	3	44	12
Үйлдвэрлэлийн салбар: Байгаль орчин	5	2	8	2	4	1	5	2	22	7
Үйлдвэрлэлийн салбар: Хөдөө аж ахуй	3	2	4	1	6	2	4	2	17	7
Үйлдвэрлэлийн салбар: Дэд бүтэц, Үүнээс	7		8		11		8		34	10
Үерээс хамгаалах		1		1		1				
Сургууль, эмнэлэг		1				1		1		
Эрчим хүч		1		1		1		1		
Нийгмийн салбар: Хүн амын шилжилт хөдөлгөөн	5	1	5	1	1	1	9	2	20	5
Нийгмийн салбар: Нийгмийн хамгаалал	5	1	5	1	3	1	7	1	20	4
Нийт	32	12	44	10	32	11	49	12	157	45

Тайлбар:

* Дэлгэрэнгүй өгсөн зөвлөмжийн тоо

** Үүнээс тусгайлан өгсөн зөвлөмжийн тоо



Food and Agriculture
Organization of the
United Nations



IOM
UN MIGRATION



UN-HABITAT






ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ДАТА МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хэмжээнд 2005-2014, 2015-2024 онд тохиолдсон
гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол, учирсан хохирол
(харьцуулсан судалгаа)

2005-2014 он	Нийт	2015-2024 он /КОВИД-19 ороогүй/
3360 /жилд дунджаар/	Тохиолдлын тоо	4550 ↑ 26% /жилд дунджаар/
2142 /нийт/	Амь насаа алдсан	2515 ↑ 14% /нийт/
7911 /нийт/	Гэмтэж бэртсэн	1255 ↓ 84% /нийт/
956 тэрбум	Учирсан хохирол	521 ↓ 45% тэрбум

Сүүлийн 20 жилд
амь насаа алдсан хүний
эзлэх хувь (хүйсээр)




Нийт амь насаа
алдсан хүний **21%**,
гэмтэж бэртсэн
хүний **4,6%**-ийг
хүүхэд эзэлж байна.

2005-2014 он	Хүүхэд	2015-2024 он
491	Амь насаа алдсан	495 ↑ 0,8%
218	Гамтэж бэртсэн	204 ↓ 6,4%

2005-2024 ОНЫ ХУГАЦААНД НИЙТ:

986 хүүхэд амь насаа алдсан

422 хүүхэд бэртэж гэмтсэн



Усны ослоос

443



Объектын гал түймрээс

360

Амь насаа алдсан хүний эзлэх хувь (гамшгийн төрлөөр)

42%

Усны осол

28%

Гал түймэр

9%



Хүний буруутай
үйл ажиллагаа

3%

Ус, цаг уурын
гаралтай

1%

Биологийн
гаралтай



ӨӨРИЙНХӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГЫНХАА АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ АНХАН ШАТНЫ ТҮВШИНД ШАЛГАЖ ХЭВШЭЭРЭЙ

“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайдын тушаалаар “Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг батлуулсан. Энэ хүрээнд Онцгой байдлын байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэд өөрсдийн аюулгүй байдлыг үнэлж, эрсдэлээ тооцоолох хялбаршуулсан асуумж бүхий хяналтын хуудсыг боловсруулж, цахим хэлбэрт шилжүүлэн Онцгой байдлын ерөнхий газрын <http://quiz.belenbai.mn/> сайтад байршуулсан.

Хяналтын хуудасны төрөл:

- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн бэлэн байдлаа шалгах хяналтын хуудас,
- өрхийн гамшгийн бэлэн байдлыг шалгах “Аюулгүй өрх” хяналтын хуудас,
- иргэний гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг шалгах асуумж



www.belenbai.mn

Гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал


Монгол Улсад зонхилон тохиолддог гамшгийн 10 төрлөөр үндэсний болон нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж аюул, өртөх байдал, эмзэг байдлын зураглалыг хүн ам, аж ахуйн нэгж, байгууллага, өрх айл, улсын чанартай авто зам, төмөр зам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, эрүүл мэнд болон боловсролын байгууллага, цахилгаан дулааны шугам сүлжээ, дэд станцууд, ургацын талбай, бэлчээрийн талбайн зэрэг 26 элементээр 500 гаруй зураглал боловсруулсан.

Үнэлгээний үр дүн, зураглалыг боловсруулахдаа Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу 5 түвшинд тодорхойлсон.

ГАМШГИЙН ТӨРӨЛ:

- Ган
- Зуд
- Газар хөдлөлт
- Хүчтэй салхи
- Үер
- Аянга
- Цасан шуурга
- Ой хээрийн түймэр
- Зоонозын өвчин
- Шороон шуурга

Боловсролын байгууллагын олон аюулд өртөх байдлын зураглал



Таних тэмдэг

Барилгын өртөх байдал

Цэцэрлэг

- ▲ Маш их
- ▲ Их
- ▲ Дунд
- ▲ Бага
- ▲ Маш бага

Их, дээд сургууль, коллеж

- ◆ Маш их
- ◆ Их
- ◆ Дунд
- ◆ Бага
- ◆ Маш бага

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

- Маш их
- Их
- Дунд
- Бага
- Маш бага

Ерөнхий боловсролын сургууль

- Маш их
- Их
- Дунд
- Бага
- Маш бага

Боловсролын байгууллага	Өртөх байдлын түвшин				
	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Цэцэрлэг	5	29	302	340	251
Ерөнхий боловсролын сургууль	4	23	256	351	206
Их, дээд сургууль, коллеж	0	0	8	66	22
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	0	1	12	9	8
Нийт	9	53	578	766	487
Эзлэх хувь	0,5%	2,8%	30,5%	40,5%	25,7%

Боловсролын байгууллагын олон аюулд өртөх байдал /Бүсийн хэмжээнд/


Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн зэрэглэл, өнгө
Маш их	5
Их	4
Дунд	3
Маш бага	2
Бага	1



Үерт өртөх байдал
бүхий сургуулийн
тоо, бүсийн
хэмжээнд эзлэх
хувь

		Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Улаанбаатар			8 (1.2%)	489 (71.3%)	189 (27.6%)	
Зүүн бүс	Дорнод	2	39	12		
	Сүхбаатар	2	33			
	Хэнтий		35	22		
	Нийт	4 (2.8%)	107 (73.8%)	34 (23.4%)		
Хангайн бүс	Архангай		6	45	13	
	Баянхонгор	14	17	30		
	Өвөрхангай	7	22	36		
	Нийт	21 (11.1%)	45 (23.7%)	111 (58.4%)	13 (6.8%)	
Баруун бүс	Баян-Өлгий		7	24	41	
	Говь-Алтай	15	30	8		
	Завхан	5	31	39		
	Увс	4	12	43		
	Ховд	9	35	11		
	Нийт	33 (10.5%)	115 (36.6%)	125 (39.8%)	41 (13.1%)	
Хойд бүс	Булган		14	30	2	
	Орхон			57		
	Хөвсгөл			76	12	
	Нийт		14 (7.3%)	163 (85.3%)	14 (7.3%)	
Төвийн бүс	Дархан-Уул		2	50		
	Сэлэнгэ		10	64	2	
	Төв		25	44	2	
	Нийт		37 (18.6%)	158 (79.4%)	4 (2%)	
Говийн бүс	Говьсүмбэр		12			
	Дорноговь	15	43			
	Дундговь	8	40	3		
	Өмнөговь	11	36			
	Нийт	34 (20.2%)	131 (78%)	3 (1.8%)		
Нийт		92 (4.9%)	457 (24.1%)	1083 (57.2%)	261 (13.8%)	

Боловсролын
байгууллагын үерт
өртөх байдлын
зураглал
/сумаар/



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛ

Монгол Улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл байгуулагдан 6 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нь зөвхөн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй тул тус зөвлөлд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд олон нийт, судалгаа шинжилгээний байгууллага, хэвлэл олон нийт зэрэг олон салбарыг хамарсан төлөөллөөс бүрдэж эрсдэлийг бууруулахад хамтын хүчин чармайлт, зорилгын доор үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, гишүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, олон улсын сайн туршлага, чиг хандлагаас суралцах зорилгоор 2024 онд олон улсын 2 удаагийн сургалтад хамруулсан.

1. НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Зүүн Хойд Азийн бүсийн төв, Дэлхийн боловсрол сургалтын төвөөс аймаг, нийслэл, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн бүрэлдэхүүнд **“Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн бууруулах үйл ажиллагаа ба эрт зарлан мэдээлэх систем”** сэдэвт сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд БНСУ-ын Инчон хотноо зохион байгуулсан.

Тус сургалтад гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн нийт 38 хүн хамрагдсан бөгөөд оролцогчид сургалтаас олж авсан мэдлэгээ өөрийн аймаг, орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, цаг үетэй зэрэгцэж бус, түрүүлж алхаж, сэтгэж, санаачилгатай ажиллах боломжийг нэмэгдүүлэх үр дүнтэй сургалт болсон.




2.

Азийн гамшгийн бэлэн байдлын төвөөс Тайландын Хаант Улсын Бангкок хотноо **“Тогтвортой хөгжил ба Гамшгийн эрсдэлийн удирдлага”** сэдэвт сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус сургалтаар гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын чиг хандлага, хот суурин газрын гамшгийг даван туулах чадавх, гамшгийн улмаас хөгжлийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө ба гамшгийн эрсдэлийн удирдлагын талаар дэлгэрэнгүй ойлголт мэдлэгийг олгосон бөгөөд сургалтад гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 10 гаруй төлөөлөл хамрагдсан.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САНХҮҮЖИЛТ

Тусгасан төсвийн хэмжээ
(тэрбум төгрөгөөр)



Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын хүрээнд Монгол Улсын 21 аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан төсвийн хэмжээ 2018 онд 2.3 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 71.1 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНЭЭС

ДОРНОД АЙМАГ:

ГЭБОНЗ-өөс аймгийн Онцгой байдлын газарт -10 хэмийн хүйтнээс +50 градусын дулаан нөхцөлд 100 метр гүн усан дотор хайгуул хийх боломжтой уснаас эрэн хайх, аврах ажиллагааны гүний шумбалтын болон гүехэн усны зориулалттай 2 дроныг шийдвэрлэж хүлээлгэн өгсөн. Тус шумбагч дроныг ашигласнаар аврах ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах, аврагчдын аюулгүй байдлыг хангах, объект илрүүлэх, эрлийн ажиллагаа явуулах зэрэг олон төрлийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой юм.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ:

Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дуут дохиог нэмэгдүүлэх зорилгоор 45,9 сая төгрөгийн үнэ бүхий 2 чанга яригч бүхий дуут дохиог усны хамгаалалттай, тусгай зориулалтын чадлын өсгөгч 1600 дБ, гаралтын чадал 129 дБ-ийн чадалтай, 1500-3000 метрийн хамрах хүрээтэй төхөөрөмж худалдан авч, зарлан мэдээллийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлсэн.



БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ:

Барилга зураг төслийн “Хот айл” ХХК-тай гэрээ байгуулж, дүүргийн 1 дүгээр хорооны орон сууцны 2 дугаар байранд 8 сая төгрөгийн зардлаар “Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ” хийлгэн, паспортжуулалтын гаргуулсан. Мөн гамшгийн нөхцөл байдлыг үнэлж, тодорхойлох зорилгоор 10,000,000 төгрөгийн үнэ бүхий Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (Дрон)-ийг худалдан авсан.



ЗАВХАН АЙМАГ:

Гамшгийн аюулын зарлан мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Цагаанхайрхан суманд 7 сая төгрөгийн үнэ бүхий гамшгийн аюулыг зарлан мэдээлэх сирень дохиотойг байршуулсан.

ОРХОН АЙМАГ:

ГЭБОНЗ-өөс 468.5 сая төгрөг шийдвэрлэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр сүүлийн үеийн дэвшилтэт техник, багаж хэрэгсэл бүхий Гал түймэр унтраах гинжит механизм /робот/, 50-60 кг ачаа тээвэрлэх, зөөвөрлөх нисгэгчгүй нисэх төхөөрөмж худалдан авах захиалгыг хийсэн.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

1. МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх;
2. гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах;
3. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах;
4. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх;
5. Орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах.

1. ГЭБОНЗ нь ГХТХ-ийн 27.2-т заасан бүрэн эрхээс гадна энэ журмыг өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
2. Орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, холбогдох зардлыг шийдвэрлэж хэрэгжилтийг хангах.
3. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, түүний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Үндэсний зөвлөлд улирал тутам тайлагнана.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

Холбоо барих:
Утас: 51-263585, 51-263579
Имэйл: undesniizuvlul@nema.gov.mn